



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/122

Улаанбаатар хот

Сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор 2016 онд
барих агнуурын загас, хавчийн өндөг олборлох
тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоох тухай

Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 35 дугаар зүйлийн 35.1, 35.2, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хар нуур, Хар-Ус нууруудын загасны тоо толгойг зохицуулах зорилгоор бариулах агнуурын загас, Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт орших давстай нууруудын экосистемийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор олборлох загалмай хөлт хавч /артеми/-ийн өндөгний тоо хэмжээний дээд хязгаарыг хавсралт ёсоор баталсугай.


2. Батлагдсан тоо хэмжээний дээд хязгаарт багтаан эрх бүхий мэргэжлийн байгууллагын удирдлагаар загас барих ажлыг 2016 оны 12 сарын 1-нээс 2017 оны 03 дугаар сарын 20-ны хооронд, хавчийн өндөг олборлох ажлыг технологийн дагуу зөвшөөрөгдсөн хэмжээнд 2016-2017 онд зохион байгуулахыг Ховд, Говь-Алтай аймгийн Засаг дарга, Хар нуур, Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга нарт тус тус даалгасугай,.

САЙД



Д.ОЮУНХОРОЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын
сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ний
өдрийн 7 дугаар тушаалын
хавсралт



Загасны сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор 2016
онд барих агнуурын загасны болон нуурын экосистемийн
тэнцвэрт байдлыг хангах зорилгоор 2016-2017 онд олборлох
заламгай хөлт хавчийн өндөгний тоо хэмжээний дээд хязгаар

№	Аймаг	Сум	Нуурын нэр	Загасны хэмжээ
1	Ховд	Ховд, Жаргалант сум	Хар нуур, Хар-Ус нуур	20 000 ширхэг
				Заламгай хөлт хавч /артеми /-ийн өндөгний хэмжээ
2	Говь-Алтай	Дарви	Ихэс нуур	80тн
		Тонхил	Тонхил нуур	10тн
			Хулам нуур	10тн

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР